

ТТАвтомашинд байршуулсан эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийг хадгалах, ариутгах, цэвэрлэх, халдваргүйтгэл хийх заавар 2023 он

ТТАвтомашинд байршуулсан эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийг хадгалах, ариутгах, цэвэрлэх, халдваргүйтгэл хийх заавар 2023 он



**БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН АВТОМАШИНД БАЙРШУУЛСАН ЭМНЭЛГИЙН
ХЭРЭГСЭЛ, БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ХАДГАЛАХ, АРИУТГАХ,
ЦЭВЭРЛЭХ, ХАЛДВАРГҮЙТГЭЛ ХИЙХ ЗААВАР**

Хувилбарын дугаар:1
Хүчин төгөлдөр болсон огноо: 2023-10-25
Баримт бичгийн дугаар:01

Баримт бичгийг хариуцах нэгж	Нийт тасаг, нэгжүүд		
Баримт бичгийн нууцлалын зэрэглэл	Дотоод	Баримт бичгийн түвшин	3
	Овог нэр	Албан тушаал	Гарын үсэг
Боловсруулсан.	Ц.Лувсандамдин Б.Эрдэнэзул	ЭМТҮЧАБ Албаны дарга Хөдөлмөрийн аюулгүй байдал, орчны эрсдэлийн менежер	
Санал өгсөн	Д.Баянмөнх	Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал	
Хянаж баталсан	Г.Дашжанцан	БООТөвийн захирал	



ТТАвтомашинд байршуулсан эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийг хадгалах, ариутгах, цэвэрлэх, халдваргүйтгэл хийх заавар 2023 он

Баримт бичгийн өөрчлөлтийн бүртгэл

Хувилбарын дугаар	Хүчин төгөлдөр болсон огноо	Өөрчлөлтийг батласан албан тушаалтан	Өөрчлөлтийн утга (баримт бичигт ямар өөрчлөлт орсоныг товч тайлбарлана)
1			
2			
3			
4			
5			
6			

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	4
2. АВТОМАШИНЫГ ЦЭВЭРЛЭХ, АРИУТГАХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА	4-5
3. АРИУТГАЛЫН ХЭСЭГТ БАГАЖ ХЭРЭГСЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ.....	6
4. БАГАЖ ХЭРЭГСЛИЙГ ЦЭВЭРЛЭХ.....	6-7
5. ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН АВТОМАШИНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ.....	7

ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН АВТОМАШИНД БАЙРШУУЛСАН ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ХАДГАЛАХ, АРИУТГАХ, ЦЭВЭРЛЭХ, ХАЛДВАРГҮЙТГЭЛ ХИЙХ ЗААВАР

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Түргэн тусламжийн автомашины дотор тал, автомашинд байршуулсан эмнэлгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх зорилгоор үйлчлүүлэгчийн гэмтсэн болон гэмтээгүй арьс салстад хүрэлцдэг, зөөлөн эд, яс, биеийн хөндийд нэвтэрдэг багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг зөв хадгалах, байршуулах, түүнийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгахад энэхүү зааврыг мөрдөж ажиллана.

1.2 Эрүүл мэндийн байгууллага нь энэхүү үйл ажиллагааг гүйцэтгэх ариутгалын тасаг, хэсэгтэй байна.

1.3 Түргэн тусламжийн автомашинд байрлуулсан багаж хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгах үйл ажиллагааг ариутгалын ажилтны мэргэжил олгох сургалтанд хамрагдсан ажилтан гүйцэтгэнэ.

1.4 Багаж хэрэгслийг эрсдэлийн түвшингээр нь 3 ангилна.

1.4.1 Өндөр эрсдэлтэй-Арьс салстыг гэмтээж, судас, дотор эрхтэн, биеийн хөндий, эд эрхтэн рүү нэвтрэн орох багаж, хэрэгсэл

1.4.2 Дунд эрсдэлтэй-Салст бүрхэвчтэй хүрэлцдэг багаж хэрэгсэл

1.4.3 Бага эрсдэлтэй-Гэмтээгүй арьс салстад хүрэлцдэг болон хүний биед хүрдэггүй багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж

1.5 Багаж хэрэгслийн цэвэрлэгээ нь органик болон органик бус бохирдлыг арилгана.

1.6 Халдваргүйжүүлэлт нь автомашинд байрлуулсан багаж хэрэгслийн бичил биетний тоог бууруулна.

1.7 Ариутгал нь багаж хэрэгсэл дэх бичил биетнийг бүрэн устгана.

Хоёр. Автомашиныг цэвэрлэх, ариутгах, халдваргүйжүүлэхэд тавигдах шаардлага

2.1 Олон дахин хэрэглэгддэг багаж тоног төхөөрөмжийг төвлөрсөн ариутгалын хэсгийн ажилтан бүртгэн авч ариутгал халваргүйтгэл хийсний дараа буцаан олгоно. Автомашинд суурилуулсан тохиолдолд автомашин дотор цэвэрлэгээ халваргүйжүүлэлт хийж, хатааж ариутгана.

2.2 Автомашинд байрлаж байгаа багаж, тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспортыг механик хариуцан хөтлөнө. Хяналтыг ЭМТҮЧАБ Албанаас хийнэ.

2.3 Автомашины цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийн тэмдэглэлийг Халдвараас сэрийлэх хяналтын албаны арга зүйн зөвлөгөөний дагуу жолооч нар

ТТАвтомашинд байршуулсан эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийг хадгалах, ариутгах, цэвэрлэх, халдваргүйтгэл хийх заавар 2023 он хөтлөн тэмдэглэнэ. Тэмдэглэхдээ цэвэрлэгээ үйлчилгээний талаар болон тухайн өдрийн он сар өдрийг заавал тэмдэглэсэн байна. (Хүснэгт 1)

2.4 Механик автомашины бүрэн бүтэн байдалд үзлэг шалгалт хийж, үйлчилгээнд гарахыг зөвшөөрсөн тухай тэмдэглэлийг хөтлөнө.

2.5 Түргэн тусламжийн автомашинд цэвэрлэгээ, ариутгал, халваргүйтгэл хийхдээ нэг хаалгыг онгойлгон хийж бусад хаалгыг хаалттай байлгана. Бүрэн цэвэрлэж дууссаны дараа бүх хаалгыг сайтар хааж хэсэг хугацааны дараа онгойлгож болно.

2.6 Автомашиныг дотор тал, эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж халдваргүйжүүлэх дарааллын дагуу халдваргүйжүүлэх бодис (энгийн өдөр тутмын цэвэрлэгээг 0,016, цус болон биологийн шингэнээр бохирлогдсон үед 0,06 хувийн жавелины) уусмалаар ариутгалын ажилтан халваргүйжүүлнэ.

2.7 “Автомашины цэвэрлэгээ”-г тухайн автомашиныг хариуцсан жолооч хамгаалах хэрэгсэл хэрэглэн өдөр тутамдаа хийнэ. Цэвэрлэгээг үйлчилгээнд гарахын өмнө бохирдолтой бол тухай бүр цэвэрлэнэ.

2.8 “Автомашины ариутгал, халдваргүйтгэл” гэдэг нь ариутгалын ажилтан халдваргүйжүүлэх бодис ашиглан хийхийг хэлнэ. Ариутгал халдваргүйтгэлийг сард нэг удаа хийх бөгөөд үйлчлүүлэгчийн цус болон биологийн шингэнээр бохирлогдсон бол бохирдсон тухай бүрт хийнэ.

2.9 Ариутгал хийх бохир автомашинд ажиллах ариутгалын ажилтан болон жолооч нь дараах хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөнө. Үүнд:

- үс далдалсан малгай
- нүдний шил эсвэл нүүрний хаалт
- шингэн нэвтрүүлдэггүй, амьсгалын зам хамгаалах амны хаалт
- шингэн нэвтрүүлдэггүй халад эсвэл хормогч
- зориулалтын зузаан халуунд тэсвэртэй бээлий болон хурц үзүүр иртэй багажинд тэсвэртэй резинэн бээлий
- хальтрахгүй ултай гутал, усны гутал, гутлын гадуурх углаа
- норсон бохирдсон үед солих даавуун цамц, өмд
- бохир хэсэгт ажилласан хувцастай цэвэр, ариун материал хадгалах хэсэг болон бусад өрөөнд орохыг хориглоно.

Гурав. Ариутгалын хэсэгт багаж хэрэгслийг хүлээн авах

ТТАвтомашинд байршуулсан эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийг хадгалах, ариутгах, цэвэрлэх, халдваргүйтгэл хийх заавар 2023 он

3.1 Ариутгалын хэсэгт бохир багаж, хэрэгслийг Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 сарын 29 ний өдрийн А/537 дугаар тушаалын “маягт-1”-ын дагуу ариутгалын хэсгийн ариутгагч хүлээн авч, хүлээлгэн өгнө.

3.2 Бохир багаж хэрэгслийг биологийн бохирдол хатахаас сэргийлж хэрэглэсэн даруйд ариутгалын хэсэгт жолооч хүргэх ба тагтай бариултай саванд тээвэрлэн хүргэж өгнө.

3.3 Шууд хүргэх боломжгүй, биологийн шингэн хатах эрсдэлтэй бол хаталтаас сэргийлсэн бодис (ус) ашиглах эсвэл цэвэрлэгээний уусмалд хэрэглэсэн даруйд хийнэ. Ариутгалын тасагт хүргэхээс өмнө багаж хэрэгслийг уусмалаас гаргаж зөөвөрлөнө.

3.4 Бохир багажийг зөөх сав нь тагтай, бариултай байна. Тэргэнцэр ашиглаж зөөвөрлөж болно.

Дөрөв. Багаж хэрэгслийг цэвэрлэх

4.1 Автомашинд цэвэрлэгээ хийсэн эсэхээс үл хамааран ариутгал, халдваргүйтгэлийг сард нэг удаа заавал хийнэ.

4.2 Цэвэрлэгээ хийх бодис нь органик бохирдол арилгах энзим (фермент) болон угаагч бодисын (детергент) найрлагатай байна.

4.3 Цэвэрлэгээний бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэнэ. Нунтаг бодис хэрэглэж байгаа тохиолдолд усанд бүрэн ууссаны дараа хэрэглэнэ.

4.4 Нэг удаа хэрэглэх зориулалттай багаж хэрэгслийг угааж, халдваргүйжүүлж давтан ашиглахгүй.

4.5 Амьсгалын аппаратыг задалж дотор талыг нь халдваргүйжүүлж ариутгана.

4.6 Амьсгалын хүрээний эд ангиудыг нэг үйлчлүүлэгчид хэрэглэх ба амьсгалын аппаратны гуурс, амьсгал гаргах хавхлага, агаар чийгшүүлэх хэрэгсэл нь гэмтсэн, илэрхий бохирдсон үед солино. Илэрхий бохирдоогүй, механик гэмтэл үүсээгүй үед солих шаардлагагүй. Дараагийн үйлчлүүлэгчид хэрэглэхийн өмнө давтан хэрэглэх эд, ангийг цэвэрлэж, халдваргүйжүүлнэ. Нэг удаа хэрэглэх хэсгийг шинээр солино.

4.7 Даралтын аппарат, пульс хэмжигч, чагнуур, зүрхний цахилгаан бичлэгийн хэрэгсэл, ЭХО-ны аппаратны датчик, бумба зэрэг бага эрсдэлтэй багаж хэрэгслийг цэвэрлэсний дараа халдваргүйжүүлнэ. Цэвэрлэгээ халдваргүйжүүлэх үйлчилгээг зэрэг үзүүлдэг хосолсон найрлагатай “Cleaning” гэх мэт бодисоор цэвэрлэгээ, халваргүйжүүлэлт хийнэ.

ТТАвтомашинд байршуулсан эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийг хадгалах, ариутгах, цэвэрлэх, халдваргүйтгэл хийх заавар 2023 он

4.8 Халдвартай өвчин, цар тахалтай үед автомашины дотор талыг цэвэрлэхийн өмнө бүх хаалгыг онгойлгож агаар сэлгэлт хийсний дараа цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэлийг хийнэ. Ингэхдээ хамгаалах хэрэгслийг бүрэн хэрэглэнэ.

4.9 Цаг агаар хүйтэрсэн тохиолдолд автомашины дотор талын цэвэрлэгээ халдваргүйтгэлийг эмнэлгийн автогражид хийнэ. Гадна ариутгал халдваргүйтгэл хийсний дараа гражийн хаалгыг 20 минут онгорхой орхиж агаар сэлгэлт хийнэ.

4.10 Автомашины гадна тал бохирлогдсон (халдварт өвчингүй) үед хамгаалах хэрэгсэл хэрэглэн цэвэрлэх эсвэл автомашин угаалгын газраар угаалгаж болно.

Тав. Түргэн тусламжийн автомашины аюулгүй байдал

5.1 Түргэн тусламжийн автомашинд ажил эхлэхийн өмнө үзлэг шалгалтыг хийж механик бүрэн бүтэн байдлыг заавал хянасны дараа үйлчилгээнд гаргах зөвшөөрөл олгоно. Техникийн бүрэн бүтэн байдалд үзлэг хийхдээ дараах дарааллыг баримтална.

1. 4 дугуй хийтэй байгаа эсэх

2. Автомашины дуут дохио ажиллаж байгаа эсэх

3. Автомашины хаалга гүйцэт хаагдаж байгаа эсэх

4. Автомашины хянах самбарт гэрэл асаалттай ямар нэгэн алдаа заагаагүй байх, мотор хэвийн дуугарч байгаа эсэхийг сонсох

5. Бензины датчик ажиллагаа хэвийн эсэх, бензин хангалттай байгаа эсэх

6. Моторын тос, маслын хэмжээг өдөр бүр хянах

7. Замын хөдөлгөөнд оролцохдоо замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийг баримтлах, хурдыг тохируулах, аюулгүйн бүсийг бүх зорчигчид зүүсэн байна.

5.2 Түргэн тусламжийн автомашины жолооч нь ээлжнээс буугаад сайтар унтаж амарсан тохиолдолд ажиллуулна.

5.3 Түргэн тусламжийн автомашины аюулгүй байдалд механик хяналт тавих бөгөөд жолооч тавьсан шаардлагыг биелүүлэн ажиллах үүргийг хүлээнэ.

5.4 Түргэн тусламжийн автомашинд тамхи татахыг хатуу хориглоно.